





ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ 2024 VIII



www.1212.mn



Дундговь аймаг
2024 он

ГАРЧИГ

Нийгмийн үзүүлэлт:

I.	Ажлын байрны зуучлал.....	3
II.	Бүртгэлтэй ажил хайгч иргэд.....	4
III.	Нийгмийн даатгал.....	4
IV.	Эрүүл мэнд.....	5
V.	Гэмт хэрэг.....	6
VI.	Гамшиг ослын мэдээ.....	7

Эдийн засгийн үзүүлэлт:

I.	Мөнгө, банк.....	8
II.	Төсөв.....	8
III.	Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ.....	9
IV.	Аж үйлдвэр.....	10

Хавсралт хүснэгтүүд

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН СТАТИСТИКЧ

Нийгмийн үзүүлэлт:

I.	Ажлын байрны зуучлал	С.Доржханд
II.	Бүртгэлтэй ажил хайгч иргэд	С.Доржханд
III.	Нийгмийн даатгал	Н.Давааням
IV.	Эрүүл мэнд	Н.Давааням
V.	Гэмт хэрэг	Г.Ариунжаргал
VI.	Гамшиг ослын мэдээ	Н.Давааням

Эдийн засгийн үзүүлэлт:

I.	Мөнгө, банк	Т.Бямбасүрэн
II.	Төсөв	Т.Бямбасүрэн
III.	Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ	Г.Ариунжаргал
IV.	Хөдөө аж ахуй	Н.Давааням
V.	Аж үйлдвэр	Т.Бямбасүрэн




Шинэ ажлын байранд 583 хүн зуучлагджээ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны 8 сарын мэдээгээр нийт 583 хүн шинэ ажлын байранд зуучлагджээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 5 хүнээр өссөн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийн 295 буюу 50.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажилд зуучилсан иргэдийн 69.5 хувь буюу 405 нь төрийн өмчит байгууллагад, 30.2 хувь буюу 176 нь хувийн хэвшилд, 1 иргэн гадаадын, 1 иргэн хамтарсан эзэмшлийн байгууллагад зуучлагджээ.

ЗУРАГ 1. АЖИЛД ЗУУЧЛАГДСАН ИРГЭДИЙН ТОО, жил бүрийн эхний 8 сарын байдлаар



Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд Хөдөө аж ахуйн салбарт 194 хүн буюу 33.3 хувь, усан хангамж, бохир ус, зайлуулах салбарт 91 хүн буюу 15.6 хувь, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагааны салбарт 88 хүн буюу 15.1 хувь, боловсролын салбарт 58 хүн буюу 9.9 хувь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 36 хүн 6.2 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 31 хүн буюу 5.3 хувь, бусад салбарт 85 хүн буюу 14.6 хувь нь зуучлагджээ.

ЗУРАГ 2. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, эдийн засгийн салбараар, хувиар






Бүртгэлтэй ажил хайгч 200 иргэн байна

2024 оны 8 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 200 хүн бүртгэгдсэн нь өмнөх сараас 42 хүнээр буурсан байна. Нийт бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 57.5 хувь буюу 115 нь эмэгтэйчүүд байна. Тус аймгийн хувьд 10000 хүнд ногдох бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 61 байна. Ажил хайгч иргэдийн 25.5 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, мөн 25.5 хувийг суурь боловсролтой иргэд, 21.0 хувийг бага боловсролтой иргэд, 12.0 хувийг техникийн болон мэргэжлийн боловсролтой иргэд, 14. хувийг дээд боловсролтой иргэд бүрдүүлж байна.

ЗУРАГ 3. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, /боловсролын түвшнээр/




Нийгмийн даатгалын сангийн орлого 10.1 тэрбумаар өссөн байна

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2024 оны эхний 8 сарын байдлаар 48.7 тэрбум төгрөг, зарлага 47.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 10.1 тэрбум төгрөгөөр буюу 24.6 хувиар, зарлага 12.3 тэрбум төгрөг буюу 34.3 хувиар тус тус өссөн байна.

Оны эхний 8 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч хүн 8589 байна. Нийт тэтгэвэр авагчдын 85.7 хувь буюу 7393 хүн өндөр насны, 9.8 хувь буюу 839 хүн тахир дутуугийн, 2.6 хувь буюу 224 хүн тэжээгчээ алдсаны, 1.9 хувь буюу 163 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ /хувиар/



Оны эхний 8 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 1088, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 22, ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 172 хүн байна.




Төрөлт өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар буурсан байна


Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2024 оны эхний 8 сарын байдлаар 380 эх төрсөн ба нийт 380 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеэс 19.5 хувиар буюу 92 төрөлтөөр буурсан байна. Төрсөн эхчүүдийн 95.8 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт 8 сарын байдлаар 0-1 насны хүүхдийн эндэгдэл 1 тохиодол, 0-5 насны хүүхдийн эндэгдэл 2 тохиолдол бүртгэгдсэн байна. Нас баралтын 149 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор буурсан байна. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт 33 буюу 22.1 хувийг эзэлж байна.

Тухайн 2024 оны 8 сарын байдлаар стационарит шинээр 7347 эмчлүүлэгч хэвтэж, 7389 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 53586 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.3 байна.

ЗУРАГ 5. ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО



ЗУРАГ 6. ЭМЧЛЭГДЭЖ ГАРСАН ХҮНИЙ ТОО



2024 оны эхний 8 сарын байдлаар 113787 амбулаторийн үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 20.0 хувь, өвчний учир амбулаторийн үзлэг 63.0 хувь, идэвхтэй хяналт 10.4


хувь, гэрийн идэвхтэй үзлэг 5.6 хувь, гэрийн дуудлагын үзлэг 1.0 хувийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.3 хувь нь эрэгтэй, 64.6 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 211 тохиолдол бүртгэгдээд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 45.2 хувь болж өмнөх оны мөн үеэс 163 тохиолдол буюу 43.6 хувиар буурсан байна.



Хулгайлах гэмт хэргийн тоо 23 болж өмнөх оны мөн үеэс 17(42.5%) хэргээр буурсан байна.

Дундговь аймаг дахь Цагдаагийн газар нь 2024 оны эхний 8 сарын байдлаар иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1157 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 96(9.0%)-р өссөн байна. 2024 оны эхний 8 сард улсын хэмжээнд 28219 гэмт хэрэг бүртгэгдсэний 187 нь Дундговь аймагт бүртгэгдсэн байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 2(1.1%) хэргээр өссөн байна.

ЗУРАГ 7. 2024 ОНЫ ЭХНИЙ 8 САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ / Өмнөх 2 оны мөн үетэй харьцуулснаар/



Бүртгэгдсэн нийт 187 гэмт хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүнийг санаатай алах гэмт хэрэг 3(3 дахин) хэргээр, хүчиндэх гэмт хэрэг 2(66.6%) хэргээр, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 27(36.9%) хэргээр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 1 хэргээр, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1(5.3%) хэргээр өссөн бол хулгайлах гэмт хэрэг 17(42.5%) хэргээр, мал хулгайлах гэмт хэрэг 1(50%) хэргээр, залилах гэмт хэрэг 8(27.6%) хэргээр, хэрэг дээрэмдэх гэмт хэрэг 1(50%) хэргээр, бусад гэмт хэрэг 3(20.0%) хэргээр, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх хэрэг 2(2 дахин) буурсан байна.

Гэмт хэргийн улмаас 178 хүн хохирч, 108 хүн гэмтэж, 6 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо 15(7.7%) хүнээр, нас барсан хүний тоо 4(40%) хүнээр буурсан бол гэмтсэн хүний тоо 22(25.6%) хүнээр өссөн байна.

Гэмт хэрэгт нийт 141 хүн холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15(11.9%) байна.

Нийт гэмт хэргийн 76(40.6%) нь согтуугаар, 13(6.9%) нь эмэгтэй хүн оролцсон, 28(14.9%) нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн, 5(2.7%) нь хүүхэд оролцсон, 4(2.1%) нь бүлэглэн гүйцэтгэсэн, 20(10.7%) нь цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг гэмт хэрэг байна.

ЗУРАГ 8. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДЛААР /Нийт гэмт хэрэгт эзлэх хувиар/



Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 8 сарын байдлаар 13218 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үеэс 3615(27.3%) зөрчлөөр өссөн үзүүлэлттэй байна. Зөрчил гаргасан 16478 иргэнийг 741.1 сая төгрөгөөр торгосон байна. Үүнээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэргээр 202 хүнийг торгон, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нь хасах, 81 хүнд баривчлах, 48 хүнд саатуулах шийтгэл тус тус ногдуулсан байна. Нийт 27 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4(13%) хүнээр буурсан байна.



Аюулт үзэгдэл, ослын 89 дуудлага бүртгэгдсэн байна

Аймгийн Онцгой байдлын газраас ирсэн мэдээгээр 2024 оны 8 дугаар сарын байдлаар аюулт үзэгдэл, ослын 89 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс объектын гал түймрийн дуудлага 23 удаа бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1(4.5%) дуудлагаар өссөн үзүүлэлт байна. Тухайн сард малын гоц халдварт өвчний дуудлага 31 удаа бүртгэгдэж, цаашид малын гоц халдварт өвчин нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Малын гоц халдварт өвчин гарсан сумдын Онцгой комиссоос хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж байгаа бөгөөд гол нь иргэдийн хорио цээрийн дэглэмийг сахиж ажиллах, малаа хариулга маллагаатай байлгахад шалтгаалж байна.

ЗУРАГ 9. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ИРСЭН ДУУДЛАГА




Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 31.6 хувиар өсжээ

Тус аймагт нийт 34 банкны салбар нэгжид 155 хүн ажиллаж байна. Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 43.0 хувиар өсч, 237.2 тэрбум төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1.4 тэрбум төгрөг, чанаргүй зээл 2.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 8.7 хувиар буурч, чанаргүй зээл 31.6 хувиар өссөн байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 1.4 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламжийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 33.6 хувиар өсч, 120.4 тэрбум төгрөг болжээ.

ЗУРАГ 10. БАНКНЫ ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөгөөр



ЗУРАГ 11. БАНКНЫ ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ, ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО, мянган хүн, дансны тоогоор




Улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 135.6 хувьтай байна

Санхүү, төрийн сангийн хэлтэс болон Татварын хэлтсийн мэдээгээр 2024 оны эхний 8 сарын байдлаар орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт 116.5 хувьтай буюу 12.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Мөн улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 135.6 хувьтай буюу 3.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна.

Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 44.1 тэрбум төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 113.5 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Баянжаргалан сум 20.4 хувиар тасалдуулсан бол бусад бүх сумд давуулан биелүүлсэн байна. Үүнээс Гурвансайхан сум 3.4 дахин, Өндөршил сум 55.5 хувиар, Дэлгэрхангай сум 37.7 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

ЗУРАГ 12. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН БҮТЭЦ, хувиар



2024 оны эхний 8 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зарлагын нийт дүн 43.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57.1 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оны мөн үеэс 68.8 хувиар өсч, 8.1 тэрбум төгрөг болсон нь нийт зардлын 18.5 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оны мөн үеэс 62.5 хувиар өсч, 0.9 тэрбум төгрөг болсон байна.

Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал бүх зардал өссөн ба үүнээс татаас 8.1 дахин бараа үйлчилгээний бусад зардал 2.1 дахин, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 2.2 дахин тус тус өссөн байна.




Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ үнийн индекс өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2024 оны 8 сарын байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.0 хувиар өсжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 5.0 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувиар, хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис дүнгээрээ 4.0 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувиар, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг дүнгээрээ 3.5 хувиар, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 13. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС /Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар/



2024 оны 8 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин, дизель түлшний үнийг орууллаа.

ХҮСНЭГТ 1. ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

№	Барааны нэр, төрөл	VIII/05	VIII/12	VIII/19	VIII/26
1	Гурил, 1-р зэрэг, кг	2 933	2 933	2 933	2 933
2	Хонины мах, кг	11 500	10 500	11 000	10 000
3	Үхрийн мах, кг	16 000	0	0	17 000
4	Ямааны ястай мах, кг	10 500	9 500	10 000	9 000
5	Элсэн чихэр, кг	4 697	4 697	4 697	4 697
6	Цагаан будаа, кг	3 963	3 963	3 963	3 963
7	Шингэн сүү, л	4 000	4 000	4 000	4 000
8	Ноолуурын үнэ 1 кг	120 000	120 000	120 000	120 000
9	Бензин А-80, 1литр	0	0	0	0
10	Бензин А-92, 1литр	2 530	2 530	2 530	2 530
11	Дизель түлш 1 литр	3 500	3 500	3 500	3 500
12	Боодолтой өвс 1 ш	0	0	0	0



Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өсжээ

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2024 оны эхний 8 сарын байдлаар 41.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өсжээ. Энэхүү өсөлтөд цахилгаан хий, уур агааржуулалтын салбар 32.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 14. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БҮТЭЦ, /нийт үйлдвэрлэлд эзлэх хувиар/



ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

I. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2024 оны 08 сарын байдлаар

Эдийн засгийн салбарын ангилал	Ажилд зуучилсан иргэд	үүнээс: эмэгтэй	Эдийн засгийн салбарын эзлэх хувь
Бүгд	583	295	100.0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй	194	85	33.3
Уул уурхай олборлох үйлдвэр	4	2	0.7
Боловсруулах аж үйлдвэр	28	15	4.8
Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт	0	0	0.0
Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог	91	22	15.6
Барилга	5	1	0.9
Бөөний ба жижиглэн худалдаа	10	8	1.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1	1	0.2
Зочид буудал, зоогийн газар	2	2	0.3
Мэдээлэл холбоо	3	2	0.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	11	11	1.9
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4	3	0.7
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	31	16	5.3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа	88	41	40.0
Боловсрол	58	50	9.9
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	36	28	6.2
Урлаг, үзвэр, тоглоом наадам	0	0	0.0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	15	6	2.6
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2	2	0.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0	0.0

II. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

Сум	Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам	Тайлант сарын эхэнд байсан ажил хайгч иргэд	Тайлант сарын эцэст байгаа ажил хайгч иргэд	Үүнээс эмэгтэй	Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажил хайгч
Дүн	32 721	242	200	115	61
Сайнцагаан	11 073	51	39	17	35
Адаацаг	1 910	1	1	1	5
Баянжаргалан	879	1	1	1	11
Говь-Угтаал	1 060	14	13	8	123
Гурвансайхан	1 548	13	7	4	45
Дэлгэрхангай	1 550	9	5	2	32
Дэлгэрцогт	1 136	20	17	11	150
Дэрэн	1 494	15	13	10	87
Луус	1 385	27	26	13	188
Өлзийт	1 704	5	2	0	12
Өндөршил	1 038	33	32	19	308
Сайхан-Овоо	1 524	11	8	3	52
Хулд	1 704	19	17	17	100
Цагаандэлгэр	701	1	1	0	14
Эрдэнэдалай	4 015	22	18	9	45

III.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ОРЛОГО, ЗАРЛАГА/сая.төг/

	2023 оны VIII сар	2024 оны VIII сар			2024 VIII 2023 VIII хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийгмийн даатгалын сангийн орлого	41 087.2	27 592.0	51 185.0	185.5	124.6
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	37 123.3	25 285.3	48 681.0	192.5	131.1
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 248.8	1 239.3	1 872.5	151.1	149.9
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1 761.1	.0	.0	0.0	0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	546.8	681.9	102.4	15.0	18.7
Ажилгүйдлийн даатгалын сангийн	407.2	385.5	529.1	137.3	129.9
Нийгмийн даатгалын сангийн зарлага	39 569.9	49 057.9	50 376.0	102.7	127.3
Үүнээс					
Тэтгэврийн даатгалын сангийн	35 626.9	44 459.2	47 872.0	107.7	134.4
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 280.5	4 006.0	1 926.9	48.1	150.5
Эрүүл мэндийн даатгалын сангийн	1 761.8	.0	.0	0.0	0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сангийн	495.1	120.7	112.9	93.5	22.8
Ажилгүйдлийн даатгалын сангийн	405.6	472.0	464.2	98.3	114.4
					-10097.8

Тайлбар: *Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

IV.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО, жил бүрийн 8 сарын байдлаар

Үзүүлэлт	2020 VIII	2021 VIII	2022 VIII	2023 VIII	2024 VIII	2024 VIII 2023 VIII хувь
	хүн					
Тэтгэвэр авагчдын тоо	7 581	7 933	8 136	8 350	8 589	102.9
Өндөр настны тэтгэвэр	6 321	6 684	6 919	7 160	7 363	102.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр	884	861	830	802	839	104.6
Цэргийн тэтгэвэр	141	147	156	163	163	100.0
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	235	241	231	225	224	99.6

V. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

сумд	төрсөн хүүхдийн тоо		Бүх нас баралт		0-1 насны хүүхдийн эндэгдэл		0-5 насны хүүхдийн эндэгдэл	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
Дүн	475	380	151	149	4	1	7	2
Сайнцагаан	451	364	72	62	4	1	5	1
Адаацаг	0	0	4	9	0	0	0	0
Баянжаргалан	2	0	6	5	0	0	0	0
Говь-Угтаал	4	0	2	3	0	0	0	0
Гурвансайхан	0	0	5	6	0	0	0	1
Дэлгэрхангай	5	3	7	8	0	0	0	0
Дэлгэрцогт	0	0	6	3	0	0	0	0
Дэрэн	0	2	8	9	0	0	1	0
Луус	0	0	5	7	0	0	0	0
Өлзийт	3	0	3	2	0	0	0	0
Өндөршил	2	2	11	5	0	0	0	0
Сайхан-Овоо	1	0	2	3	0	0	0	0
Хулд	2	0	3	1	0	0	0	0
Цагаандэлгэр	2	0	2	1	0	0	0	0
Эрдэнэдалай	3	9	15	25	0	0	1	0

VI. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 8 сарын байдлаар

Сумд	Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо		Бүгд үзлэг		Бүртгэгдсэн бүх өвчлөл		Халдварт өвчин бүгд		үүнээс /зарим үзүүлэлтээр/			
									сүрьеэ		Салхин цэцэг	
	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024	2023	2024
Дүн	6 981	7 347	114 477	113 787	36 206	32 213	374	211	7	15	142	105
Сц	3 749	3 978	89 708	85 560	30 769	26 857	233	158	4	8	95	81
Ад	163	208	1 720	2 316	534	141	39	3	2	2	7	
Бж	111	114	697	1 249	122	198	2	5			2	4
Гу	120	236	1 412	1 812	791	484	9	2			2	2
Гс	90	132	1 190	1 458	308	37	7	12		2	4	7
Дх	190	204	1 309	660	62	40	3	2				1
Дц	135	159	881	641	147	171	7	4	1			1
Дн	125	108	1 324	1 774	185	230	6	9			1	7
Лс	125	173	1 648	1 948	103	109	5	5			1	1
Өт	104	101	1 572	1 345	114	82	36	3		1	27	
Өш	196	129	1 272	1 392	317	128	3					
Со	86	84	460	636	190	234	7				2	
Хд	84	100	644	604	164	64	6	4		1		1
Цд	111	141	629	517	276	253	3					
Эд	310	471	7 573	9 113	1 869	2 792	8	4		1	1	
Мд	167		171									
Эб	261	150	260	152								
МУЭ төв	854	859	2 007	2 610	255	393						

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

VII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-1

Үзүүлэлт	2023 VIII	2024 VIII	23/24 хувь
Оны эхний 18 ба түүнээс дээш насны хүний тоо	30578	29933	97.9
Бүх хэрэг	185	187	101.1
Хүнийг санаатай алах гэмт хэрэг	0	3	-
Хүчиндэх гэмт хэрэг	3	5	166.7
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	2	0	-
Дээрэмдэх гэмт хэрэг	2	1	50.0
Хүрээлэн байгаа орчны эсрэг	0	1	-
Танхайн хэрэг	0	0	-
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	73	100	137.0
Бусдын эд хөрөнгийн хулгай	40	23	57.5
Малын хулгай	2	1	-
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг	19	20	105.3
Залилангийн хэрэг	29	21	72.4
Эдийн засгийн гэмт хэрэг	0	0	-
Бусад	15	12	80.0
Эмэгтэй хүн оролцсон	22	13	12.0
Согтуугаар	43	76	176.7
Бүлэглэж	3	4	133.3
Хүүхэд оролцсон	5	5	100.0
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	7	28	400.0
Хөнгөн	163	153	93.9
Хүнд	22	34	154.5
Гэмт хэрэгт холбогдогсод	126	141	111.9
Учирсан бүх хохирол /сая.төг/	722.7	640.9	88.7
Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/	289.7	378.0	130.5
Илрүүлэлтийн хувь	58.2	61.3	105.3
18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/	61	62	103.3

VIII. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ-2

№	Үзүүлэлтүүд	2023 VIII	2024 VIII	2023/2024 хувь
1	Гэмт хэргийн улмаас:	96	114	118.8
	Нас барсан	10	6	60.0
	Гэмтсэн	86	108	125.6
2	Зам тээврийн осолын улмаас:	18	6	33.3
	Нас барсан	7	3	42.9
	Гэмтсэн	11	3	27.3
3	Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо /Үүнээс/	193	178	92.2
	Эмэгтэй	68	73	107.4
	7 хүртэлх насны	5	1	20.0
	8-13 насны	1	4	400.0
	14-17 насны	5	6	120.0
4	Бүх хүлээн авсан өргөдөл, гомдол мэдээлэл	1061	1157	109.0
	Бүх шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй ӨГМ	382	445	116.5
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн	129	161	124.8
	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	247	278	112.6
	Харьяаллын дагуу шилжүүлсэн	6	6	100.0
	Үлдэгдэл	24	41	170.8
	Бүх шийдсэнээс 5 хоногт шийдвэрлэсэн	51	48	94.1
	6-ба түүнээс дээш	331	397	119.9
5	Бүх шийдвэрлэсэн захиргааны зөрчлийн шинжтэй өргөдөл гомдол мэдээлэл /Үүнд/	646	671	103.9
	5 хоногт	554	661	119.3
	6 ба түүнээс дээш	92	-	-
	Үлдэгдэл	9	10	111.1
6	Нийт зөрчил	13218	16833	127.3
7	Илрүүлсэн зөрчил			
	ЗЦТасгаас илрүүлсэн	7698	6960	90.4
	НХЖХТасгаас илрүүлсэн	5520	7143	129.4
8	Тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасч, торгосон	213	201	94.4
9	Баривчлагдсан хүн	134	81	60.4
10	Журамласан тээврийн хэрэгсэл	268	202	75.4
11	Эрүүлжүүлэгдсэн хүн	31	27	87.1
12	Саатуулагдсан хүн	47	48	102.1
13	Зөрчлийн хуулиар арга хэмжээ авагдсан			
	Хүний тоо	12857	16478	128.2
	Мөнгөн дүн /мян.төг/	626417.1	741098.5	118.3

Х. ГАМШГИЙН МЭДЭЭ

Үйл ажиллагаа	2023 оны VIII сар	2024 оны VIII сар	2023/2024 хувь
Нийт ирсэн дуудлага	85	89	104.7
Объектын гал түймрийн	22	23	104.5
Хүчтэй салхи шуурга	0	1	0.0
Усны осол	30	1	3.3
Төөрсөн сураггүй болсон	7	9	128.6
Зам тээврийн осол	3	1	33.3
Уурхайн осол	1	0	0.0
Аянга	0	0	0.0
Малын гоц халдварт	20	31	155.0
Цас, шаварт суусан	2	21	0.0
Газар хөдлөлт	0	2	0.0
Дуудлагын үр дүн			
Аварсан хүн	37	117	316.2
Аварсан хөрөнгө /сая.төг/	1282.0	1861.1	145.2
Хохирол /сая.төг/	458.2	378.1	82.5
Иргэд ААН-д хандсан үйл ажиллагаа			
ААН-ийн хүсэлт	69	78	113.0
Иргэдийн өргөдөл	52	31	59.6
Хяналт шалгалт			
Хамрагдсан объект	148	118	79.7
Илэрсэн зөрчил	286	227	79.4
Газар дээр нь арилгасан	123	96	78.0
Албан шаардлага	57	53	93.0
Мэдэгдэл	76	59	77.6
Торгууль /сая.төг/	500	200	40.0

Х. ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ БАНКНЫ САЛБАРЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр, тоогоор

Үзүүлэлт		Үлдэгдэл		2024/2023 хувь
		2023 VIII	2024 VIII	
Зээл	Нийт зээлийн үлдэгдэл	165 920.5	237 236.4	143.0
	Үүнээс: Анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл	1 482.7	1 354.3	91.3
	Чанаргүй зээлийн үлдэгдэл	1 498.5	1 972.6	131.6
Татан төвлөрүүлсэн хөрөнгө	Нийт харилцахын үлдэгдэл	32 459.6	41 233.7	127.0
	Үүнээс: Иргэдийн харилцахын үлдэгдэл	21 544.7	30 284.0	140.6
	Нийт хадгаламжийн үлдэгдэл	90 143.2	120 394.3	133.6
	Үүнээс: Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	90 108.3	115 336.2	128.0
	Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл	16 176.1	24 873.1	153.8
	Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл	73 967.1	95 521.2	129.1
Тоон мэдээлэл	Нийт банкны салбар, нэгжийн тоо	34	34	100.0
	Нийт банкны салбар, нэгжийн ажилтнуудын тоо	160	155	96.9
	Нийт зээлдэгчийн тоо (дансны тоогоор)	27 035	27 800	102.8
	Нийт харилцах данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	90 825	93 298	102.7
	Нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо (дансны тоогоор)	32 254	34 718	113.7
	Нийт АТМ-ны тоо	19	20	105.3
	Нийт төлбөрийн карт эзэмшигчийн тоо	43 816	42 082	96.0

ХI. ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

Сумд	2024 I-VIII			2024 VIII		
	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
Дүн	13520862.5	19568147.2	144.7	1320095.8	1448579.6	109.7
Сайнцагаан	5229378.0	5800471.8	110.9	554331.2	574322.1	103.6
Адаацаг	331010.0	361362.3	109.2	22350.0	34870.9	156.0
Баянжаргалан	1299571.5	1034205.7	79.6	190482.5	31020.7	16.3
Говь-Угтаал	349257.1	374252.3	107.2	26100.0	59382.7	227.5
Гурвансайхан	1471030.4	5008498.8	340.5	63367.4	85537.2	135.0
Дэлгэрхангай	456110.0	628087.0	137.7	33500.0	100300.2	299.4
Дэлгэрцогт	236330.0	245655.1	103.9	14820.0	10541.9	71.1
Дэрэн	254290.0	286998.8	112.9	16230.0	28716.9	176.9
Луус	251080.0	278826.8	111.1	16390.0	21292.1	129.9
Өлзийт	1176698.3	1289224.1	109.6	122859.6	75996.1	61.9
Өндөршил	282666.0	439658.5	155.5	16940.0	85319.1	503.7
Сайхан-Овоо	296685.0	333131.5	112.3	22605.0	39370.1	174.2
Хулд	297018.0	377660.1	127.2	20536.0	37641.2	183.3
Цагаандэлгэр	163920.0	173089.8	105.6	13740.0	33276.6	242.2
Эрдэнэдалай	736240.0	774300.2	105.2	53850.0	69297.2	128.7
Дундговь	689578.2	2162724.4	313.6	131994.1	161694.6	122.5

ХII. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр

Зарлагын төрөл	2023 VIII	2024 VIII			24/23 хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
Нийт зарлага	27 880.3	65 757.5	43 786.5	66.6	157.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4 793.7	8 914.1	8 092.7	90.8	168.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	574.8	1 138.8	933.8	90.8	162.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3 423.6	5 303.2	4 887.6	82.0	142.8
Хангамж бараа материалын зардал	344.3	620.4	380.8	61.4	110.6
Норматив зардал	62.3	120.8	104.7	86.7	-
Эд хогшил урсгал засварын зардал	372.2	956.4	429.0	44.9	115.3
Томилолтын зардал	151.1	258.7	195.3	75.5	129.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	518.0	2 415.2	1 126.5	46.6	217.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2 091.7	6 821.4	4 402.4	64.5	210.5
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	.0	.0	.0	-	-
Татаас	170.1	1 389.6	1 372.5	98.8	806.9
Засгийн газрын дотоод шилжүүлэг	6 377.2	9 587.4	9 502.6	99.1	149.0
Бусад урсгал шилжүүлэг	92.2	1 309.2	1 057.2	80.8	-
Хөрөнгийн зардал	7 594.2	24 646.4	11 261.4	45.7	148.3
Эргэж төлөгдөх зээл	1 314.9	2 275.9	40.0	1.8	-

ХИИ.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	мөр	2023 VIII	2024 VIII			24/23
			төл	гүйц	хувь	хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого /тусламжийн дүн/	1	24 202.7	38 881.1	44 133.7	113.5	182.4
А.Урсгал орлого	2	7 287.7	11 658.1	16 565.2	142.1	227.3
I.Татварын орлого	3	6 165.0	11 082.3	12 907.5	116.5	209.4
1.1 Хүн амын орлогын албан татвар	4	3 790.8	8 149.5	10 285.5	126.2	271.3
1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар	5	3 808.6	5 969.7	6 468.2	108.4	169.8
Хувь хүний орлогын албан татварын буцаалт	6	- 406.7	- 601.9	- 601.8	100.0	148.0
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	7	146.7	952.4	1 900.0	199.5	1295.2
1.2 үйл ажиллагааны орлого	8	155.0	1 248.6	1 736.9	139.1	1120.6
1.3 Хөрөнгө борлуулсаны	9	84.8	73.8	185.5	251.4	218.8
1.5 Бусад татвар	10	2.4	506.9	596.7	117.7	24862.5
2.Хөрөнгийн татвар/ҮХХболон буу/	11	108.7	113.6	155.4	136.8	143.0
3. Авто тээврийн хэрэгслийн	12	295.7	293.8	313.8	106.8	106.1
4. Бусад татвар	13	1 969.8	2 525.4	2 152.8	85.2	109.3
4.1 Улсын тэмдэгтийн	14	83.3	102.6	176.2	171.7	211.5
4.2 Ашигт малтмал нөөцийн	15	6.6	67.3	6.1	9.1	92.4
4.3 Газрын төлбөр	16	1 059.1	1 170.2	865.4	74.0	81.7
4.5 Хог хаягдалын үйлчилгээний	17	75.3	110.5	96.6	87.4	128.3
4.6 Усны төлбөр	18	252.7	272.2	521.5	191.6	206.4
4.7.Малд ногдуулах татвар	19	440.7	802.6	336.9	42.0	76.4
4.8.Бусад	20	52.1	.0	150.1	-	288.1
II.Татварын бус орлого	21	1 122.7	575.8	3 657.7	635.2	101.6
2.1 Бусад нэр заагдаагүй	22	1 122.7	575.8	3 657.7	635.2	325.8
Б. Хөрөнгийн орлого	23	171.8	23.0	124.1	539.6	72.2
В.Тусламжийн орлого	24	16 743.2	27 200.0	27 444.4	100.9	163.9
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	25	10 365.9	18 027.3	18 027.3	100.0	173.9
Аймаг нийслэлээс авсан татаас	30	5 116.5	6 617.3	6 861.7	103.7	134.1
Сум дүүргээс авсан тэгшитгэл	31	1 260.8	2 555.4	2 555.4	100.0	202.7
Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй /	32	7 459.5	11 681.1	16 689.3	142.9	223.7
Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого	33	1 850.7	2 430.7	3 297.1	135.6	178.2
Аймгийн нийт орлого	34	9 310.2	14 111.8	19 986.4	141.6	214.7

XIV. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ 8-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/

	Нэр төрөл	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь	Дорноговь
1	Гурил, дээд зэрэг /Алтантариа/	3 233	3 133	3 417	3 050
2	Гурил, 1-р зэрэг /Алтантариа/	2 950	2 817	2 927	2 700
3	Гурил, 2-р зэрэг /Алтантариа/	2 217	1 867	1 987	1 900
4	Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай	2 200	2 300	2 183	2 033
5	Талх, орон нутгийн үйлдвэрийн	2 413	2 733	2 583	3 033
6	Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/	6 283	5 517	4 993	4 533
7	Жигнэмэг /наша марка/150-180г, цайны/	2 963	2 050	1 930	1 800
8	Цагаан будаа, задгай, кг	3 963	4 050	4 200	3 533
9	Шар будаа, задгай, кг	3 200	2 767	3 125	2 700
10	Хонины мах, кг	11 667	10 500	13 000	14 500
11	Адууны мах, кг	10 667	-	13 000	14 167
12	Ямааны мах, кг	10 667	8 500	12 000	11 000
13	Дотор мах, цувдай, цусгүй	7 000	13 500	10 000	5 000
14	Хиам чанасан, 1кг	16 133	-	-	15 767
15	Сүү, задгай, л	4 000	3 500	6 000	4 250
16	Сүү савласан,1л. Шимт сүү	5 547	5 333	5 537	5 533
17	Хорхой ааруул, задгай, чихэртэй	26 667	35 000	33 333	30 000
18	Өндөг,ш,дотоод	673	685	657	617
19	Ургамлын тос, 1литр, Олайна	11 167	9 833	10 993	6 000
20	Өөхөн тос, кг	-	-	-	4 000
21	Шар тос, кг	28 333	50 000	35 000	42 500
22	Цэцгийн тос, задгай, кг	9 333	8 133	7 700	5 600
23	Төмс дотоод, кг	2 433	2 000	2 483	2 167
24	Лууван хятад, кг	3 030	1 867	2 850	3 333
25	Байцаа хятад, кг	2 563	2 467	2 763	2 500
26	Сонгино хятад, кг	2 963	2 567	3 000	3 167
27	Элсэн чихэр, кг, орос	4 697	4 667	4 690	4 200
28	Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/	12 633	12 167	11 217	12 750
29	Шоколад, "Alpen gold"	3 467	3 850	3 587	3 733
30	Давс, цагаан, 1 кг, йоджуулсан	2 997	3 067	3 743	3 000
31	Майноз, /Улаанбаатар 500г/	7 063	5 500	6 650	6 850
32	Кетчуп, 900г, Чили Полиш	3 563	4 983	4 317	3 100
33	Ногоон цай, Stimo, савласан 90г	4 050	4 133	2 633	3 083
34	Байхуу цай, Lipton, 20 ширхэгтэй	4 997	4 483	5 030	4 200
35	Цагаан архи, 0.75 ARKHI EXPORT	29 200	29 933	26 330	30 100
36	Пиво, "Cass", 0.5л	4 397	4 100	4 047	3 767
37	Янжуур тамхи, /Esse/, саарал	4 033	3 900	3 633	3 450
38	Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи	3 033	2 783	2 417	2 210
39	Бензин, А-80, 1 литр	-	2 460	-	-
40	Бензин, А-92, 1 литр	2 530	2 480	2 548	2 520
41	Дизель түлш, 1 литр	3 500	3 460	3 530	3 520

ХV. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

	2024 VIII 2023 VIII	2024 VIII 2023 XII
ЕРӨНХИЙ ИНДЭКС	105.0	103.7
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	111.1	109.5
01.1 ХҮНСНИЙ БАРАА	110.8	109.1
01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА	109.8	104.6
01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГ ДЭХҮҮН	114.8	130.6
01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГ ДЭХҮҮН	132.9	121.6
01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГ ДЭХҮҮН, ӨНДӨГ	113.4	92.9
01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС	105.0	111.3
01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ	97.9	102.5
01.1.7 ХҮНСНИЙ НОГОО	109.0	108.7
01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР	109.7	106.5
01.1.9 БЭЛЭН ХООЛ, ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГ ДЭХҮҮН	118.7	112.9
01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	113.5	112.4
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	104.0	102.1
02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА	107.8	104.0
02.2 ТАМХИ	102.2	101.3
03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ	102.7	101.4
03.1 ХУВЦАС, БӨС БАРАА	101.8	100.8
03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА	100.1	100.1
03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС	102.0	100.9
03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ	102.6	100.6
03.2 ГУТАЛ	104.0	102.3
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	104.6	104.0
04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС	100.9	100.9
04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	103.2	103.2
04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	136.0	136.0
04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	101.6	100.6
Барааны бүлгээр	2024 VIII 2023 VIII	2024 VIII 2023 XII
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	102.9	101.5
05.1 ГЭР АХУЙН ТАВИЛГА, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР	102.4	101.1
05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ	113.8	106.4
05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА	99.7	99.7
05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА	99.8	99.8
05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ	108.9	105.7
05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	101.8	101.3
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	103.5	102.1
06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ	104.2	102.3
06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ	104.3	104.3
07. ТЭЭВЭР	99.8	98.4
07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ	100.0	100.0
07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ	99.7	97.5
07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.3	100.3
08.2 МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ	101.0	101.0
08.3 МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ	104.5	102.0
09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	104.6	100.0
09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ	104.7	101.9
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	117.4	107.1
11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	117.5	107.0
11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	124.1	118.4
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	110.1	108.9
12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ	111.6	110.1
12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ	101.3	101.0
12.5 ДААТГАЛ	113.3	113.3
12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	100.0	100.0

XVI. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ , оны үнээр, сая төгрөгөөр

Аж үйлдвэрийн салбар	2023 VII	2024 VII	2024/2023
Нийт дүн	35 431.8	41 232.3	116.4%
Уул уурхай олборлолт	29 974.4	34 549.8	115.3%
Чулуун нүүрс олборлолт	23 201.6	10 001.5	43.1%
Хүрэн нүүрс олборлолт	117.2	.0	0.0%
Чулуу, элс шороо олборлолт	2 720.0	252.4	9.3%
Дээрх ангилалд ороогүй бусад ашигт малтмалын олборлолт	3 935.6	24 295.9	617.3%
Боловсруулах үйлдвэрлэл	1 305.6	1 608.4	123.2%
Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл	975.3	1 244.7	127.6%
Малын тэжээлийн үйлдвэрлэл	108.8	8.6	7.9%
Үслэг арьсан хувцаснаас бусад хувцас үйлдвэрлэл	37.7	5.6	14.9%
Модон, үйсэн, үртсэн болон холтсон бүтээгдэхүүний үйлдвэрлэл	7.7	13.3	172.7%
Хэвлэх болон хэвлэлийн туслах үйл ажиллагаа	145.8	235.3	161.4%
Дээр дурдсан ангид ороогүй төмөрлөг бус эрдэс бүтээгдэхүүний бусад үйлдвэрлэл	8.4	10.5	125.0%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	21.9	90.4	412.8%
Уур, агааржуулагчийн хангамжийн үйл ажиллагаа	2 636.3	3 490.3	132.4%
Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	2 636.3	3 490.3	132.4%
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	1 515.5	1 583.8	104.5%
Хог хаягдлыг цуглуулах	1 211.4	1 325.5	109.4%

XVII. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2023 VIII	2024 VIII	2024/2023 хувь
Нүүрс	мян.тн	381.3	93.1	24.4
Жонш	мян.тн	21.0	29.9	142.4
Дулааны эрчим хүч	мян.гкал	86.2	111.3	129.1
Хүснэгт, маягт	х.д.х	150.3	187.2	124.6
Талх	тн	87.4	87.0	99.5
Нарийн боов	тн	102.4	120.7	117.9
Бялуу	тн	1.7	1.6	94.1
Чихэр	тн	1.4	0.9	64.3
Архи	мян.л	5.5	5.8	105.5
Хэрчсэн гурил	тн	12.2	7.0	57.4
Хоормог	мян.л	0.2	0.04	20.0
Ааруул	тн	0.3	0.2	66.7
Түгээсэн цэвэр ус	мян.т ³	156.5	169.9	108.6
Сувагжуулалт	мян.м ³	104.4	114	109.2

Мэдээлэл авах холбоосууд:
<http://www.dundgovi.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь:
2024 оны 10 сарын 15



Дундговь аймгийн Статистикийн хэлтсийн
дарга Б.Энхтуяа
Утас: (976)-70593777

Ахлах мэргэжилтэн Т.Бямбасүрэн
Мэргэжилтэн С.Доржханд
Мэргэжилтэн Н.Давааням
Мэргэжилтэн Г.Ариунжаргал
Утас: (976)-70593715



/StatisticMGL



Dundgovi@nso.mn



70593715



ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

110

Авлигыг мэдээлэх утас